

**Mongolian A: literature – Higher level – Paper 1**  
**Mongol A: littérature – Niveau supérieur – Épreuve 1**  
**Mongol A: literatura – Nivel superior – Prueba 1**

Wednesday 10 May 2017 (afternoon)

Mercredi 10 mai 2017 (après-midi)

Miércoles 10 de mayo de 2017 (tarde)

2 hours / 2 heures / 2 horas

---

**Instructions to candidates**

- Do not open this examination paper until instructed to do so.
- Write a literary commentary on one passage only.
- The maximum mark for this examination paper is **[20 marks]**.

**Instructions destinées aux candidats**

- N'ouvrez pas cette épreuve avant d'y être autorisé(e).
- Rédigez un commentaire littéraire sur un seul des passages.
- Le nombre maximum de points pour cette épreuve d'examen est de **[20 points]**.

**Instrucciones para los alumnos**

- No abra esta prueba hasta que se lo autoricen.
- Escriba un comentario literario sobre un solo pasaje.
- La puntuación máxima para esta prueba de examen es **[20 puntos]**.

Доорх хоёр зохиолын **аль нэгийг** сонгон тайлбарлаж бич.

1.

Хэрэйдийн Ван хаан Найман аймаг лугаа байлдаж дарагдан, улсаа автаад дэмий буруулан одож, хүнсээ барсны тул, тэмээ ба морио ханаж цусыг идэн бүхүйг Тэмүжин сонсоод, эцэг лүгээгээн анд болсныг санаж бүрүүн, авч ирүүлэхээр хүн зарж хүнс илгээгээд бас биеэр угтаж, Туул мөрний захад хурим бэлдээд, Ван хааныг эцгийн зэргээр хүндлэв.

5 Тэмүжин бээр Салчуд аймгийг дайлаар одоод, эсрэгдэн байлдахуйд, Тэмүжиний цэрэг ихэд дарагдаж бүрүүн, Тэмүжиний бие нь самуун цэргийн дотор хаагдан, мориноос унасанд, Боорчи даруй Тэмүжинийг өргөж өөрийн моринд унуулаад явганаар байлдан гарч чадахгүй бачимдаж атал, Мухулай, Чулуун, Буурал гурвуул Тэмүжинийг эрж явсаар, 10 гэнэт учраад, Мухулай даруй дайсны нэгэн хүнийг алж, морийг булаан авч, Боорчид унуулан, дөрвөн баатар хүчлэн байлдаж, Тэмүжинийг самуун цэргийн дотроос гаргаад буруулан эчтэл (*одтол*), гэнэт цас орж, их шуурга болсноор, хүрээнээс төөрч хээр хонохуйд, дөрвөн түшмэл нь морины тохмын эсгийг Тэмүжиний дээр цасыг халхлахаар дөрвөн өнцгөөс тэлэн бариад огторгуй гэгээртэл, гишгэсэн газраас хөлөө эс дэвшүүллээ. 15 Манагар (*маргаааш*) нь цэрэг лүгээгээн нийлээд, Тэмүжиний гуч илүү морьтныг авч, газрын байдлыг үзэхээр уулын хавцлаар эчтэл, ойн дотроос гэнэт дайсны бүгсэн цэрэг гараад, мөндөр мэт харвалахуйд, Мухулай тэргүүлэн гурван хүнийг харван алсанд, хулгайчийн эрхэм нь асууруун: “Чи хэн хэмээгч буй?”. “Би Мухулай хэмээгч мөн.” хэмээн өгүүлээд, эмээлээр Тэмүжинийг халхлан, Боорчи Буурал хоёул хоёр этгээдэд хавчин хашиж 20 буруулахуйд, дайсны этгээд нэхэж ирэхүйг Чулуун хүлээн авч дөрвөн хүнийг алсанд, хулгайч нар айж хоцорлоо. Түүнээс Тэмүжин цэргээ авч буцвай. Бас Тэмүжин аливаа дайнд мордвоос л, Боорчи шөнө бүр Тэмүжиний хоносон гэрийг цагдан манахын тул, Тэмүжин амархан нойрсдог ажгуу. Түүгээр Тэмүжин даруй Мухулай, Боорчи, Буурал, Чулуун дөрвүүлийг чин зоригт баатар хэмээн сайшаагаад дөрвүүлд Хүлэг хэмээн цол 25 өгвэй.

Жүрчидийн Чуу нэрт хүн харвах намнахад мэргэн бүлгээ. Нэгэн цагт Тэмүжинийг хулгайч лугаа байлдан атал, хоёр нугас нисч ирэхийг Тэмүжин үзэд Чуу-г “Харва.” хэмээсэнд, Чуу асууруун: “Борчин, борогчин хоёрын алиныг харваму.” хэмээсэнд өгүүлрүүн: “Борчныг нь харвагтун!” хэмээсэн даруйд борчныг нь харваж унагасанд, 30 хулгайч нар айж өгүүлэлдэн, энэ хүн жигүүртэн шувууг гаргахгүй бөгөөтөл, хүнийг юун өгүүлмүй хэмээлдээд, байлдсангүй орж өглөө. Түүгээр Чуу-д Мэргэн хэмээн цол өгөв.

Тэмүжин цэрэг авч Монголжины аймгийг дайлан одоод, Монголжины эзэн Тоду лугаа Мунан нэрт уулын бэлд байлдаж, Тоду-гийн цэргийг ихэд дараад, түүний хүн хийгээд эд малыг нь ихэд олзолсноо цөм Хэрэйдийн Ван хаанд өгөв. Төдий Ван хааны иргэн өчүүхэн  
35 олдсоноор, Агсу нэрт газраа нутаглаж бүрүүн, өөрийн цэргээ авч басхүү Монголжиныг дайлахуйд, Монголжины цэрэг ихэд дарагдаад, Тоду-гийн бие нь Баргужин нэрт газар дутааж одов. Ван хаан ихэд олзлоод, тэр олзоо Тэмүжинд өчүүхэн ч эс өглөө. Бас Тэмүжин, Ван хаан лугаа хоёул цэрэг авч Найман аймгийн эзэн Болай хааныг дайлаар одоод, Хэшигбай нэрт талд хүрч хүрээ буусан хойно, Самагу аймгийн эзэн нь хүн зарж,  
40 Ван хаанд өгүүлрүүн: “Бид хоёул цагаан жигүүрт бялзуухай мэт, бусад бүгд галуунд адил болой. Цагаан жигүүрт бялзуухай халуун ба хүйтэн болбоос бээр мөнхүү умар газарт амуй. Галуу нь хүйтэн болоход дулааныг эрж өмнөх газарт одмуй за. Тэмүжиний сэтгэлийг итгэж хэр болмуй” хэмээсэн хойно, Ван хаан тэр үгэнд орж, мөн шөнө хүрээн дотроо гал тавьж, ихэд шатаагаад цэргээ авч эгэж, Туул мөрөнд буулаа. Манагар өглөө  
45 нь Тэмүжин үзээд, Ван хаанд өөр санаатай ажгуу хэмээн цэргээ аван Сали мөрөнд ирж буувай. Найман аймгийн Чубай нэрт жанжин цэрэг авч Ван хааныг нэхэн ирж байлдаад дарж бүрүүн, улсын олныг нь олзлоод аван одсонд, Ван хаан даруй өөрийн хөвгүүн Илаху жанжин Болгудай хоёулаар нэхүүлэн, бас Тэмүжинд хүн зарж энэ учрыг өгүүлээд, чамд дөрвөн сайн жанжин буй бүлгээ. Хоромхон илгээж надад туслах ажаамуу хэмээсэнд,  
50 Тэмүжин даруй урьдын мууг үл сэтгэн, дөрвөн хүлэгт цэрэг өгч явуулав.

Рашпунцаг, *Болор эрих* (2006)

2.

- Үүрд энхийн заяат эх орны минь алдар Монгол!  
Үлэмжийн сайхнаа ардынхаа зүрхэнд юүлэх мөнх урсгал  
Хүн болсон төрх төлөв минь аугаа таны бүтээл  
Хүй бие минь өнгөрсөн одоо ирээдүйн огтлол  
5 Үзэж, сонсож, амталж, үнэрлэж, хүрэлцэх, миний таван цэнгэл
- Өгөөж наран, тэнгэр мэлмийгээрээ намайг хайрлан харна, Та  
Өргөл болгож дуугаа дуулахад түүний минь уяран сонсоно, Та  
Өвгөдийн хайр шингэсэн хөрс шороо гол усаараа үнсэнэ, Та  
Үүлсэн сүрэгтэй салхин мэдрүүлээрээ хацар үнэрлэнэ, Та  
10 Өвс ногоо, цэцгэн сэвлэгээрээ намайг илбэн мэдэрнэ, Та
- Энх жаргалан, эрхэм төгөлдөр бүхний учир утга  
Эв найрамдал, эсэн мөнхийн уран зангидлага  
Эх хэлнийхээ айзам аялгуугаар сүлжих өлзий утас  
Өр зүрхний баяр болж долгилох миний найргийн судас  
15 Өнө үүрд хувиршгүй хайрыг минь илчилж дуурс!
1.  
Өнгийн цэцэгс нь өөрөө өлзий утас мэтгэж  
Өлмийд дэвсэн удаан жаргал ерөөнө  
Наран завьяа нь илч гэрлээр мэлтэлзэж  
20 Намайг хараад мэлмийн баяр мэдэрнэ.
- Эрхийн чинээ чулууны уран судлыг бүрдүүлсэн  
Эцэс төгсгөлгүй мөнхийн их уран дархан  
Эрхэм дээд танаасаа үүсэхээс илүү аз заяа үгүй  
Элбэрэлтэйеэ, төгс төгөлдөр эх орон минь үү
- 25 Мөрөн голын ус нь уулс хааны эрдэнийн очир бөгж  
Мөнгөн сар нь янаг хайрын үлгэр хүүрнэх гүнж  
Цэцгийн цоморлиг нь нар хурын дээж сөгнөсөн жүнз  
Цэн хунгийн сүрэг нь нуураа гоёсон угалз
- Харахуйяа, угалз, хээ уран гоо бүхэн буюу та  
30 Өнөөгийн бидний эхлэл өвөг дээдэс минь буюу та  
Өнө үүрдийн үргэлжлэл үр хүүхэд минь буюу та  
Уншихуйяа, мөнхөд дуусашгүй хөлгөн судар буюу та
- Онгон цэнхэр талын чулуу болгон цэдэг  
Олон үеийн салхин баллуурт арилаагүй домог  
35 Овоо толгодын амин шим цогцос бүхэн үсэг  
Он цагийн уртад нууцаа сэм тайлах бичиг
- Алтан гадсанд аргамжаатай хоёр шарга од  
Асар тэнгэрийн морь дэлхийн хүлэгтэй ураг худ  
Амгалан дэлхийдээ эргэцэх хиймэл дагуул тод  
40 Авхаалжит оюун ухаанаар хязгааргүйг ширтсэн холч нүд

Жаргалтайяа, төгс төгөлдөр эх орон минь үү та  
Билигдэхүйеэ, өлзий утасны учир утган буюу та  
Дуулахуйяа, шүлэг найргийн минь амин урсгал буюу та  
Баясахуйяа, сэтгэлийн минь догдлол болгон буюу та

- 45 Үеийн үед та гоо сайхан, сүр жавхлан оршмуу  
Үрийн үрд үзэж үл гүйцэж, магтаж эс ханамуу  
Хайрлан бахархах бүрий та улам сайхан больюу  
Хатан зориг, эрдэм билэг таны тулд буюу.

Г Мэнд-Ооёо, *Өлзий утас* (1984)

---